



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/067/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.Umnugovi@audit.mn">www.Umnugovi@audit.mn</a> Өмнөговь аймаг  2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn Аудитор: Ө.Болортуяа Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
5.1 Төлбөрийн акт .....	9
5.1 Албан шаардлага.....	9
5.2 Зөвлөмж .....	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	12

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539. Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.06.12 № 51  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН  
СУМЫН 16 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ А.МӨНГӨНТУЯА ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүй 12,365,0 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл олгосон,
- Албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй,
- Ээлжийн амралтын олговрыг олгохдоо мэдэгдэл, ээлжийн амралтын олговор бодсон хуудас хөтлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлэгийн 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.3 дахь хэсэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4626050043

1/2 Бичиг хэрэг/2026он/СТА-н дүгнэлт/Төсөл ДСХ

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант оны 3 дугаар сараас 1 бүлэг нэмэгдэж, нийт 4 бүлэгтэйгээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 47,795.1 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 59,335.3 мянган төгрөгийн "Нутгийн дэм" урамшуулал, 13,799.9 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл, 43,432.1 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт олгосон байна.

### **Бусад асуудал хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 87.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ЦӨСӨХБАЯР

F:\2 Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,207,497.78	90,614,330.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	111,249,028.61	22,757,480.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	111,249,028.61	22,757,480.80
3121	Төгрөг	111,249,028.61	22,757,480.80
31211	Төрийн сангийн харилцах	111,249,028.61	22,757,480.80
33	АВЛАГА	00.00	1,230,002.85
335	Бусад авлага	00.00	1,230,002.85
3351	Байгууллагаас авах авлага	00.00	1,230,002.85
35	БАРАА МАТЕРИАЛ	52,958,469.17	66,626,846.47
351	Түүхий эд материал	8,615,748.47	8,615,748.47
35110	Тусгай зориулалттай материал	8,615,748.47	8,615,748.47
354	Хангамжийн материал	44,342,720.70	58,011,098.00
35410	Бичиг хэргийн материал	1,008,200.00	1,008,200.00
35420	Аж ахуйн материал	9,259,450.00	9,259,450.00
35450	Барилгын засварын материал	5,715,600.00	5,715,600.00
35460	Хүнсний материал	9,919,422.70	2,177,800.00
35470	Бусад хангамжийн материал	18,440,048.00	39,850,048.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	478,168,674.07	498,267,279.81
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	478,168,674.07	498,267,279.81
392	Биет хөрөнгө	474,828,674.07	494,927,279.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	394,214,903.00	394,214,903.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,288,053.79	-41,858,302.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	65,412,570.00	85,561,370.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,611,550.33	-42,595,433.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,282,471.56	63,846,471.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17,184,442.01	-24,687,874.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	113,759,300.00	113,759,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-46,739,814.36	-58,296,444.74
39217	Ном	4,983,290.00	4,983,290.00
393	Биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,340,000.00	3,340,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	642,376,171.85	588,881,609.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,651.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	2,651.99
413	Өглөг	00.00	2,651.99
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	2,651.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	642,376,171.85	588,878,957.94
51	Засгийн газрын хувь оролцоо	642,376,171.85	588,878,957.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	370,271,284.46	370,271,284.46
51101	Өмч: - төрийн	3,340,000.00	3,340,000.00
51102	- хувийн	366,931,284.46	366,931,284.46
512	Хуримтлагдсан үр дүн	172,512,407.36	119,015,193.45
51210	Өмнөх үеийн үр дүн	172,512,407.36	172,512,407.36

Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-53,497,213.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,592,480.03	99,592,480.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	642,376,171.85	588,881,609.93

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	509,122,862.00	624,601,695.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	112,336,062.00	198,703,195.00
120	Нийтлэг татварын бус орлого	112,336,062.00	198,703,195.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,520,942.00	121,080,395.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	150,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,520,942.00	120,930,395.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	23,815,120.00	58,712,800.00
120006	Газрын тосны орлого	00.00	18,910,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	396,786,800.00	425,898,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	362,118,000.00	382,466,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	362,118,000.00	382,466,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,668,800.00	43,432,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,668,800.00	43,432,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	485,346,105.47	678,098,908.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	485,346,105.47	678,098,908.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	469,415,809.99	666,532,054.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,257,833.52	481,079,734.14
210101	Үндсэн цалин	202,419,185.59	289,673,104.11
210102	Нэмэгдэл	101,822,438.42	167,316,585.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,065,000.00
210104	Урамшуулал	3,016,209.51	13,025,044.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,846,021.50	57,363,288.71
210201	Тэтгэврийн даатгал	29,367,957.04	39,584,151.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,293,443.00	4,399,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,229.15	1,900,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,169,658.06	2,100,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,665,734.25	9,378,937.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,226,676.52	28,865,245.32
210301	Гэрэл, цахилгаан	3,101,916.32	3,140,484.72
210302	Түлш, халаалт	21,324,765.00	21,324,765.00
210303	Цэвэр, бохир ус	4,799,995.20	4,399,995.60
2104	Хангамж, бараа материалын зардал	6,604,885.00	5,310,900.00
210401	Бичиг хэрэг	3,312,900.00	3,270,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,312,085.00	456,818.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	979,900.00	1,584,082.00
2105	Нормативт зардал	48,081,932.30	47,653,972.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	102,000.00	386,000.00
210502	Хоол, хүнс	47,979,932.30	47,267,972.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,919,100.00	3,000,000.00

**Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

210604	Урсгал засвар	2,919,100.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	229,300.00	1,707,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	229,300.00	1,707,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,250,061.15	41,551,314.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	294,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,693,861.15	38,614,194.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,930,295.48	11,566,854.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,407,272.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,407,272.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,523,023.48	11,566,854.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,523,023.48	11,566,854.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	23,776,756.53	-53,497,213.91

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	485,307,742.00	546,978,895.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,520,942.00	121,080,395.00
120	Нийтлэг татварын бус орлого	88,520,942.00	121,080,395.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,520,942.00	121,080,395.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	150,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,520,942.00	120,930,395.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	396,786,800.00	425,898,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	362,118,000.00	382,466,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	362,118,000.00	382,466,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	34,668,800.00	43,432,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	34,668,800.00	43,432,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	454,100,277.02	635,470,442.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	454,100,277.02	635,470,442.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,169,981.54	623,903,588.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,257,833.52	482,145,204.80
210101	Үндсэн цалин	202,419,185.59	290,738,574.77
210102	Нэмэгдэл	101,822,438.42	167,316,585.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,065,000.00
210104	Урамшуулал	3,016,209.51	13,025,044.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,846,021.50	57,363,288.71
210201	Тэтгэврийн даатгал	29,367,957.04	39,584,151.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,507,245.50	4,399,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,135,426.65	1,900,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,169,658.06	2,100,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,665,734.25	9,378,937.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,226,676.52	28,865,245.32
210301	Гэрэл, цахилгаан	3,101,916.32	3,140,484.72
210302	Түлш, халаалт	21,324,765.00	21,324,765.00

**Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	4,799,995.20	4,399,995.60
2105	Нормативт зардал	47,427,965.00	39,526,349.30
210502	Хоол, хүнс	47,427,965.00	39,526,349.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,919,100.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,919,100.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	229,300.00	1,707,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	229,300.00	1,707,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,263,085.00	11,295,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,751,185.00	8,308,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,511,900.00	2,987,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,930,295.48	11,566,854.68
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,407,272.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,407,272.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,523,023.48	11,566,854.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,523,023.48	11,566,854.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,207,464.98	-88,491,547.81
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,207,464.98	-88,491,547.81
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	80,041,563.63	111,249,028.61
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	111,249,028.61	22,757,480.80

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>370,271,284.46</b>	<b>99,592,480.03</b>	<b>-2,856,847.52</b>	<b>467,006,916.97</b>
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	-2,856,847.52	467,006,916.97
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-16,416,699.79	-16,416,699.79
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>370,271,284.46</b>	<b>99,592,480.03</b>	<b>172,512,407.36</b>	<b>642,376,171.85</b>
D01	<b>2025 оны 1-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>370,271,284.46</b>	<b>99,592,480.03</b>	<b>172,512,407.36</b>	<b>642,376,171.85</b>
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,271,284.46	99,592,480.03	172,512,407.36	642,376,171.85
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-53,497,213.91	-53,497,213.91
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>370,271,284.46</b>	<b>99,592,480.03</b>	<b>119,015,193.45</b>	<b>588,878,957.94</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	525,633,100.00	503,546,795.00
12	Татварын бус орлого	525,633,100.00	503,546,795.00

Өмнөговь аймгийн Ноён сумын 16 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	142,855,500.00	121,080,395.00
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	142,855,500.00	121,080,395.00
122	Тусламжийн орлого	382,777,600.00	382,466,400.00
122005	Төсвөөс санхүүжих	382,777,600.00	382,466,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	627,103,200.00	592,038,342.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	627,103,200.00	592,038,342.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	627,103,200.00	592,038,342.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	501,546,300.00	482,145,204.80
210101	Үндсэн цалин	315,363,900.00	290,738,574.77
210102	Нэмэгдэл	181,291,100.00	167,316,585.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	11,065,000.00
210104	Урамшуулал	4,891,300.00	13,025,044.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,420,200.00	57,363,288.71
210201	Тэтгэврийн даатгал	42,358,200.00	39,584,151.21
210202	Тэтгэмжийн даатгал	5,015,500.00	4,399,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,507,800.00	1,900,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,507,800.00	2,100,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,030,900.00	9,378,937.50
2105	Нормативт зардал	48,113,200.00	39,526,349.30
210502	Хоол, хүнс	48,113,200.00	39,526,349.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,284,300.00	1,707,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,284,300.00	1,707,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,739,200.00	11,295,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,830,900.00	8,308,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,908,300.00	2,987,100.00
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(101,470,100.00)	(88,491,547.81)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	101,470,100.00	88,491,547.81
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	101,470,100.00	88,491,547.81
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	111,249,028.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	22,757,480.80

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 176,018.9 мянган төгрөгийн 8 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 176,018.9 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- ✓ Тайлант онд 312,555.32 төгрөгийн гэрэл цахилгааны зардлыг түлш, халаалтын зардлаар тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Санхүүгийн байдлын тайланд 54,724,564.77 төгрөгийн тайлант үеийн үр дүнг илэрхийлээгүй нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгө өмчийн дүнг өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын хувь оролцооны дүнтэй тулган шалгахад 54,724,564.77 төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- ✓ Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнтэй тулган шалгахад 54,724,564.77 төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Тайлант онд 2,651.99 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тайлагнаагүй нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Тайлант онд 1,230,002.84 төгрөгийн ХХОАТ-ын авлагыг тайлагнаагүй нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Тайлант онд 10,300,000 төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга,” болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Сангийн сайдын хүчингүй болсон 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар 1 зөрчилд албан шаардлага, 5 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 16,674.4 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 11,822.5 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул “Өөрчлөлттэй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт:** Тайлант онд байгууллыгн "Хөдөлмөрийн дотоод журам"-д тусгаагүйгээр 12,365.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.3-д "Ажил олгогч энэ хуульд зааснаас өөр төрлийн олговрыг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтоон олгож болно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан хаагчдад олгох хоолны нэмэгдлийг байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт заалтаар оруулж батлах тухай албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

**Илрүүлэлт-1:** Цалингийн зардлаас 4,309.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

**Илрүүлэлт-2:** Тайлант онд байгууллагын албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлэгийн 1-д "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг бүрэн хэрэгжүүлж, анхан шатны баримтыг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

**Илрүүлэлт-3:** Тайлант онд албан хаагчдад ээлжийн амралтын олговрыг олгохдоо ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл, ээлжийн амралтын олговор бодсон хуудас хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1-д "нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.3-д "Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийн дагуу энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг байгууллагын холбогдох нэгж болон ажилтанд олгоно", 1 дүгээр хавсралт "ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл", 2 дугаар хавсралт "ээлжийн амралтын цалингийн тооцоо" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ыг бүрэн хэрэгжүүлж, анхан шатны баримтыг хангаж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

**Илрүүлэлт-4:** Тайлант онд эрхлэгчийн Б/34б, Б/35б дугаартай тушаалуудыг давхардуулсан бичиг хэргийн стандартыг мөрдөөгүй, хуулийн нэр буруу бичсэн, үгийн алдаатай гаргасан байна.

Энэ нь Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-д "Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх

*ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина", Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 1.4-д "Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 3.1-д заасан зарчмыг баримтлах бөгөөд арга зүйн хувьд нэгдмэл, бүртгэл төвлөрсөн, баримт бичгийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал, түүний ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангасан байна" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.*

**Шийдвэрлэсэн нь:** Архив, албан хэргийн стандартыг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

**Илрүүлэлт-5:** Тайлант онд Шилэн дансны мэдээллийн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 450,121.2 мянган төгрөгийн орлогын дүнг мэдээлээгүй, 3 мэдээлэл хугацаа хоцроосон, 2025 оны хагас жилийн баталгаажуулаагүй санхүүгийн тайлан мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруул			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		аагүй		Тоо	Дүн
Тайлант онд 1,230.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг тайлагнаагүй	1	1,230.0	1	1,230.0			1	1,230.0				
Санхүүгийн байдлын тайланд 54,724.6 мянган төгрөгийн тайлант үеийн үр дүнг илэрхийлээгүй	1	54,724.6	1	54,724.6			1	54,724.6				
Тайлант онд 2.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тайлагнаагүй	1	2.6	1	2.6			1	2.6				
Тайлант онд 10,300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг олгохдоо өглөгөөр хүлээн зөвшөөрч тайлагнасан	1	10,300.0	1	10,300.0			1	10,300.0				
Санхүүгийн байдлын тайлангийн цэвэр хөрөнгө өмчийн дүнг өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын хувь оролцооны дүнтэй тулган шалгахад 54,724.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн	1	54,724.6	1	54,724.6			1	54,724.6				
Санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнтэй тулган шалгахад 54,724.6 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэн	1	54,724.6	1	54,724.6			1	54,724.6				
Санхүүгийн үр дүнгийн тайланд 312.6 мянган төгрөгийн гэрэл цахилгааны зардлыг түлш, халаалтын зардлаар тайлагнасан	1	312.6	1	312.6			1	312.6				
<b>ДҮН</b>	<b>7</b>	<b>176,019.0</b>	<b>7</b>	<b>176,019.0</b>			<b>7</b>	<b>176,019.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хөдөлмөрийн дотоод журамд тусгаагүйгээр 12,365.0 мянган төгрөгийн хоолны нэмэгдэл олгосон	1	12,365.0			1	12,365.0							
Байгууллагын албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй олгосон	1	30,487.0					1	30,487.0					
Тайлант онд цалингийн зардлаас 4,309.4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн	1	4,309.4					1	4,309.4					
Албан хаагчдад ээлжийн олговор олгохдоо ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл, ээлжийн амралтын олговор бодсон хуудас хөтлөөгүй	1	61,818.4					1	61,818.4					
Тайлант онд эрхлэгчийн Б/34б, Б/35б дугаартай тушаалуудыг давхардуулсан	1	0					1	0					
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>108,979.8</b>			<b>1</b>	<b>12,365.0</b>	<b>4</b>	<b>96,614.8</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээллийн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 450,121.2 мянган төгрөгийн орлогын дүнг мэдээлээгүй, 3 мэдээлэл хугацаа хоцроосон, 2025 оны хагас жилийн баталгаажуулаагүй санхүүгийн тайлан мэдээлсэн	1	450,121.2						1	450,121.2
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>450,121.2</b>						<b>1</b>	<b>450,121.2</b>